

Нэгдмэл тайлагнал: хэрэгжилт - ажиглалт

Integrated Reporting: Implementation - Observation

Ч. Чимидсүрэн¹

Хураангуй

Нэгдмэл тайлагнал бол санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг нэгтгэн, бүрэн дүр зургаар байгууллагын үнэ цэнийг товч тодорхой мэдээлэхийг зорьдог. Практикт энэ асуудал эхлэлийн шатандаа байна. Нэгдмэл тайлагнал гэж юу вэ, түүний ач холбогдол нь юу вэ, түүнийг яаж тайлагнах вэ гэдэг асуултуудад олон компаниудын хувьд эргэлзээтэй байна. Энэ сэдвээр 2014 оны Дэлхийн нягтлан бодогчдын чуулга уулзалт (Итали), 2015 оны Ази номхон далайн нягтлан бодогчдын олон улсын хурал (Солонгос), 2018 оны Нэгдмэл тайлагналын олон улсын зөвлөл болон Компанийн засаглалын олон улсын сүлжээний хамтран зохион байгуулсан хурал (Япон)-уудад хэлэлцэгдсэн зарим анхлан хэрэгжүүлэгчид, зохицуулагч байгууллагын төлөөлөл болон судлаачид, тэдний судалгааны материалд тулгуурлан нэгдмэл тайлагналын өнөөгийн байдал дэлхийн зарим улс оронд хэрхэн хэрэгжиж байгааг ажигласан судалгааны тухай авч үзсэн.

Түлхүүр үгс: нэгдмэл тайлан, Нэгдмэл Тайлагналын Олон Улсын Зөвлөл, Нэгдмэл тайлагналын үзэл баримтлал, үнэ цэнийг бий болгох, санхүүгийн бус мэдээлэл, эдийн засаг, нийгэм хүрээлэн буй орчин, засаглалын тайлагнал

Abstract

Integrated reporting seeks to concisely communicate a company's value through the holistic picture that integrates financial and non-financial information. This new innovation of reporting is the first stage of development. There are still many issues: what is the integrated reporting, what is the importance of integrated reporting, why does it matter, how to report etc. This article is summarized survey and interviewees of researchers, regulators, practitioners that was held in World Congress of Accountants (Italy, 2014), Confederation of Asian and Pacific Accountants Conference (Korea, 2015), ICGN-IIIRC Conference (Tokyo, 2018).

Keywords: integrated report, International Integrated Reporting Council, Integrated Reporting Framework, value creation, non-financial information, economic, environment, governance

¹ Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт (ММНБИ)-ийн дэд ерөнхийлөгч
E-mail: chimidsuren@monicpa.mn

Тайлагналын талаар

Бизнесийн байгууллагын зорилго нь зөвхөн ашиг олох гэдэг ойлголт өнөө үед үгүй болж компани нь эдийн засаг санхүүгийн ашиг хүртэхээс гадна байгаль дэлхийдээ ээлтэй үйл ажиллагаа явуулах, нийгэм хүрээлэн буй орчиндоо эерэг өөрчлөлтийг бүтээж, нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж, тогтвортой хөгжлийг чухалчилдаг болжээ. Үүнтэй холбоотойгоор компанийн санхүүгийн тайлан, засаглал, бизнес модель, нийгэм, хүрээлэн буй орчин, хэтийн төлвийн талаар мэдээллийг нэгтгэсэн тайлангийн эрэлт нийгэмд их байна. Энэ эрэлт нь сонирхогч бүхий л талаас гарч ирж байна, тухайлбал хөрөнгө оруулагч, зохицуулагч байгууллагууд, бэлтгэн нийлүүлэгч, ажилчид гэх мэт (KPMG, 2013). Өнгөрсөн хугацаанд санхүүгийн тайлан нь зөвхөн компанийн санхүүгийн байдлыг харуулж байсан бол өнөө үед нэгдмэл тайлан нь компанийн тухай цогц мэдээлэл бүхий үнэ цэнийг өргөн дүр зургаар тайлагнадаг болж байна. Нэгдмэл тайлагнал нь байгууллагын стратегийг илүү ил тод, бизнес моделийн тогтвортой байдалд итгэх итгэлийг бий болгодог. Одоогоор ил тод байх эрэлт ихсэж байгаа ч Америк, Австрали, Япон зэрэг ихэнх оронд маш цөөн компани нэгдмэл тайланг гаргаж байна (IIRC, 2016). Япон улсад 385 компани нэгдмэл тайланг гаргаж байна (ICGN-IIRC Conference, 2018). ОХУ-д 166 компани санхүүгийн бус мэдээллээ тайлагнаж байна (rspp.ru/simplepage/157)

Нэгдмэл тайлагнал гэж юу вэ?

Олон улсын нэгдмэл тайлагналын зөвлөл (ОУНТЗ) нь дэлхийн нягтлан бодогчдын холбоо (IFAC), Глобал тайлагналын санаачлага (GRI), Уэльсийн

ханхүүгийн тогтвортой байдлын төлөөх нягтлан бодох бүртгэл (A4S) төсөл зэрэг зохицуулагч болон стандарт тогтоогч байгууллагуудын байгуулсан олон улсын эвсэл юм. Тус эвсэлийг профессор Мервин Кинг удирдаж байна. Үнэ цэнийг бий болгож буйг тайлагнах нь компанийн тайлагналын дараагийн хувьсал байх хэрэгтэй (IIRC, 2015). ОУНТЗ нь “Нэгдмэл тайлан гэдэг нь аливаа байгууллагын бодлого стратеги, засаглал, үр дүн, хэтийн хандлага, гадаад орчин нөхцлийнхөө хүрээлэлд урт, дунд, богино хугацаанд үнэ цэнийг хэрхэн бий болгогчийг харуулсан товч тодорхой мэдээ мэдээлэл бүхий тайлан юм” гэж тодорхойлсон (IIRC, 2015). Нэгдмэл тайлан нь хүрээлэн буй орчин, нийгмийн үзүүлэлтийн тухай санхүүгийн бус мэдээллийг уламжлалт санхүүгийн мэдээлэлтэй нэгтгэхийг зорьдог. Санхүүгийн бус үзүүлэлт нь нэгдмэл тайлагналд бизнесийн үнэ цэнийг бий болгож буйг илэрхийлдэг. Нэгдмэл тайлагнал нь уламжлалт тайлагналыг шинэчилж өөрчлөх хөшүүрэг болсон (Norrtman, 2014). Энэ тайлан нь санхүүгийн капитал, үйлдвэрлэлийн капитал, оюуны капитал, хүн капитал, нийгмийн харилцааны капитал, байгалийн капиталын ашиглалт, түүний өсөлт, бууралтаар үнэ цэнийг бий болгож буйг харуулдаг. Хэрэв нэгдмэл тайлан нь зорилгоо бүрэн агуулж хэрэгжүүлж чадвал байгууллагын бүрэн зураглалыг хөрөнгө оруулагч, сонирхогч бүх талуудад хүргэж чадна. Маш олон төрлийн тайлагналын загвар байдаг. Тиймээс санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллээ яаж тайлагнах вэ гэдэгт компаниуд их хүндрэлтэй тулгардаг. Уламжлалт жилийн тайланд бага зэргийн санхүүгийн бус мэдээллийг агуулсан байдаг. Гэтэл санхүүгийн бус

тайлан ихэвчлэн (засаглалын тайлан, нийгмийн хариуцлагын тайлан, хүлэмжийн хийн ялгарлын тайлан, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайлан гэх мэт) тодорхой нэг асуудалд чиглэсэн байдаг. Нэгдмэл тайлан нь бизнесийн стратегийг мэдээлэхэд хамааралтай санхүүгийн бус мэдээллийг багтааснаар олон оролцогч талуудын гүүр болж байна. Хавсралт 1 болон Хавсралт 2-оор нийт 7 төрлийн тайлангийн төрлийг харуулсан. Тэдгээрийг дурьдвал, Жилийн санхүүгийн тайлан, Нэгдмэл тайлан, Нийгмийн хариуцлагын тайлан, Хүлэмжийн хийн ялгарлын тайлан, Тогтвортой байдлын тайлан, Засаглалын тайлан, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайлангууд болно.

Нэгдмэл тайлагналын хүлээн зөвшөөрөлт

Өнөөг хүртэл нээлттэй компаниуд нь нэгдмэл тайлан гаргаж байгаа цорын ганц улс бол Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс (ӨАБНУ) юм. Тус улсын нэгдмэл тайлан гаргаж буй компаниуд бизнес моделийг тодорхойлж тайлагнахад сиенержи үүсгэх нь чухал юм гэдэгт санал нэгтэй байна (Roberts, 2014). Америкт нэгдмэл тайлагнал хөгжлийн эхэн шатанд байна, тухайлбал 100 том компанийн 51 хувь нь санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллээ жилийн тайландаа нэгтгэдэг. Энэ нь тодорхой зорилгын хүрээнд хийгддэг (KPMG, 2013). Энэ нэгтгэж байгаа хэлбэр нь цаашдын нэгдмэл тайланг бэлтгэх алхам болно. Япон улсад сүүлийн 5 орчим жил зарим компаниуд энэ туршилтад хамрагдаад байна (ICGN-IIRC, 2018). Гэвч ОУНТЗ-ийн үзэл баримтлалын зорьсоноор бол компанийн бизнесийн бүрэн зураглалыг харуулж чадахгүй байна. Компанийн нийгмийн хариуцлагыг жилийн

тайландаа тусгадаг компаниудын 5 орчим хувь нь ОУНТЗ-ийн үзэл баримтлалын дагуу нэгдмэл тайлангаа гаргаж байна. Судалгаанд хамрагдсан нэгдмэл тайлагналыг гаргаж байгаа компаниудаас Азид 71 хувь, Европд 73 хувь нь санхүүгийн бус мэдээллийн зарим хэсгийг аль хэдийн гаргаж эхэлжээ. Мөн түүнчлэн ӨАБНУ, Бразил, Австралийн хөрөнгийн биржүүд нэгдмэл тайланг тодруулахыг компаниуддаа зөвлөмж болгосон байна (KPMG, 2012). ОУНТЗ-ийн үзэл баримтлал нь албан ёсоор батлагдсан учраас эдгээр бүс нутгуудад болон бусад улс оронд нэгдмэл тайлан тархаж хурдацтай хөгжих нөхцөл байдал бүрджээ. Тиймээс нэгдмэл тайлагналын бодит туршлага, нэгдмэл тайлагналыг ойлгох нь чухал юм.

Анхлан хэрэгжүүлэгч - ӨАБНУ

ӨАБНУ-ын нэгдмэл тайлагналын түүх судлаачдын анхаарлын төвд байдаг. Ер нь ӨАБНУ бол нэгдмэл тайлагналын өлгий нутаг юм. Нэгдмэл тайлантай холбоотой түүх 1994 онд эхэлсэн. Тухайн үед ӨАБНУ-ын зохицуулагч байгууллагууд болон сонирхогч талууд нь компаниудын бизнес түүнийг тайлагнасан тайлан мэдээнд итгэх итгэл маш сул байсан. Үндэсний бизнест олон нийтийн итгэлцлийг дахин сэргээх зорилгоор тус улсын Ерөнхийлөгч Нельсон Мандела Компанийн засаглалын хааны хороог байгуулж тэргүүнээр нь Мэрвин Кингийг томилсон. 1994-2009 оны хооронд гаргасан цуврал тайлангуудаас Кинг кодексын загварыг гаргасан. Энэхүү кодексын дагуу компанийнхаа үйл ажиллагааг ил тод, үнэн зөв, хариуцлагатайгаар хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид болон сонирхогч талуудад тайлагнаж байхыг компаниудад шаардсан. 2008 оны эдийн засгийн хямрал нь уламжлалт жилийн тайлан нь

цаашид сонирхогч талуудын хэрэгцээг хангаж чадахгүй гэдгийг нотолсон. Кинг-III кодексоор олон нийтийн бизнест үл итгэх итгэлийг хүлээн зөвшөөрсөн ба илүү цогц нэгдсэн байдлаар санхүү болон тогтвортой байдлыг харуулахыг санал болгосон. Мөн Кинг-III нь “тайлагна эсвэл тайлбарла” гэсэн зөвлөмж гаргасан. Түүний дараа Хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй компаниудыг нэгдмэл тайлан гаргаж байхыг шаардах болсон. 2010 оноос компаниуд нь нэгдмэл тайлагналыг тодруулга болгох ёстой, тодруулаагүй бол яагаад тодруулаагүй гэдгээ тайлбарлах ёстой болсон. ӨАБНУ-ын нэгдмэл тайлагналын хороо нь Кинг-III дээр үндэслэн нэгдмэл тайлагналыг хэрхэн бэлтгэж гаргах баримт бичгийг хөгжүүлэх зорилготой байгуулагдсан. Одоо “тайлагна эсвэл тайлбарла” гэсэн зөвлөмж нь Бразил, ӨАБНУ, Япон, Дани, Австрали зэрэг орнуудад жишиг болон хэрэгжиж байна (ICGN-IIRC Conference, 2018).

Судалгаанд ашиглагдсан мэдээ

Нэгдмэл тайлагналын манлайлагч, ОУНТЗ-ийн гишүүд, мэргэжлийн байгууллагын удирдлага, нэгдмэл тайлагналыг хэрэгжүүлэгч, нэгдмэл тайланг баталгаажуулагч нарын төлөөлөл бүхий илтгэгчдийн судалгааны материал нь энэхүү судалгааны материал болж байна. Эдгээр судлаач, илтгэгч нар доорх сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өргөнөөр хийж байна. Үүнд: Нэгдмэл тайлагнал гэж юу болох, түүний ирээдүйн талаар; яагаад энэ сэдэв асуудал болоод байгаа талаар; нэгдмэл тайланг бэлтгэх, хэн бэлтгэх, хэрхэн бэлтгэх тухай; хууль, дүрэм, журам, албан болон албан бус зохицуулалтын асуудлууд; баталгаажуулалт болон итгэлцэл; хүрээлэн буй орчин, нийгэм,

засаглалын мэдээлэл гэх мэт орно. Эдгээр сэдвүүдийг нэгдмэл тайланг хэрэгжүүлэхэд чухал хэмээн сонгож авсан.

Нэгдмэл тайлагнал яагаад анхаарах асуудал болоод байна вэ?

Судлаач, илтгэгч нар энэ тайлангийн хэр чухал болохыг сүүлийн жилүүдэд хэлэлцэж байна. Түүний зорилго бол уламжлалт жилийн тайлантай хүрээлэн буй орчин, нийгмийн болон засаглалын мэдээллийг холбохыг зорьдог. Мөн байгууллагын гадаад дотоод үр ашгийг бий болгодог. Компанийн нэгдмэл үзлийг хүлээн зөвшөөрдөг ба гадаад болон дотоод тайланг хэрэглэгч рүү компанийн үнэ цэнийн тухай мэдээлдэг. Дотооддоо мэдээллийн чанар, урсгалыг сайжруулснаар өртөг, зардлыг бууруулж, үнэ цэнийг бий болгох маш сайн ойлголтыг олж авдаг. Гадаад талдаа компанийн бодитой үнэ цэнийг одоогийн болон ирээдүйн хөрөнгө оруулагч, сонирхогч талуудад мэдээлнэ. ОУНТЗ-өөс гаргасан судалгааны баримт бичгүүдээс гадна илтгэгч нар, академик мэргэжилтэн, практикт туршигч нарын судалгаанаас харахад нэгдмэл тайлагналын тухай, түүний ач холбогдол, хэрхэн нэвтрүүлэх гэх мэтийг олон нийт төдийлөн сайн мэдэхгүй байна. Энэ бага танигдсан байгаа нь нэгдмэл тайлагналын тухай мэдлэг дутмаг байгаагаас хамаарч байна. Түүнчлэн нэгдмэл тайлагналын хэрэгжилтийн үр дүнг илүү таниулах хэрэгтэй байна. Нэгдмэл тайлагнал бол тайлагналын хувьсгалд маш том алхам, шинэ үе шат болно гэж дүгнэж байна. Бизнесийн нарийн төвөгтэй байдал, нийгмийн ач холбогдол зэргийг бизнестээ тусгаж, бизнесийн үйл ажиллагаагаа удирдах, ойлгох, хэмжихэд шаардагдах хэрэгслийг бий болгоход ирээдүйд том алхам болно.

Нэгдмэл тайлагналын дотоод үр ашиг Зохицуулагч, илтгэгч, судлаачдын хэлэлцүүлэг, ярилцлагаас үзэхэд дотооддоо олон тооны үр ашигтай зүйл байна гэж үзсэн. Тухайлбал:

Нэгдүгээрт, үнэ цэнийг бий болгохыг илүү сайн ойлгох нь шийдвэр гаргахад тустай. IIRC, EY, KPMG-ийн судалгаа бас үүнийг баталсан байдаг. Инноваци болон суралцах хандлага нь суурь чиглүүлэгч болно. Санхүүгийн бус тайлагнал нь бас компанийн үйл ажиллагааны суурь чиглүүлэгч болно. Нийгмийн хариуцлага нь яаж бизнесийн үр ашгийг бий болгох вэ, бизнес моделийн элементүүд яаж холбогдох вэ гэдгийг мэдсэнээр дотоодод үр ашиг нэмэгдэж байгааг компаниуд хүлээн зөвшөөрч байгаа нь судалгаанаас харагдаж байна. Нэгэн илтгэгчийн илтгэлээс эш татахад “Бизнес моделд анхаарлаа хандуулснаар..., материаллаг байдлыг тодорхойлох..., бизнес бол удирдагдсан, тайлагнагдсан байх ёстой. Бизнес модельд үнэ цэнийг хэрхэн бий болохыг тодорхой илэрхийлэх, бизнесийн шийдвэр гаргахад инноваци нь чухал юм...”.

Хоёрдугаарт, нэгдмэл тайлагнал нь хэлтэс хоорондын хамтын ажиллагаа, ойлголцол, уялдаа бий болсон үед гарч эхэлдэг. Нэгдмэл тайлагнал бол хамтад нь асуудлаа тавьдаг, хамтадаа ажилладаг. Нэгэн судлаач үүнийг хөндөхдөө “Тусдаа бодох тухай асуудал алга болж байна” гэсэн бол өөр нэгэн судлаач хэлэхдээ сайжруулсан дотоод мэдээлэл нь хамгийн сайн нөөцийн хуваарилалтыг удирдаж, өртөг зардлыг бууруулна.

Гуравдугаарт, нэгдмэл тайлан бол хэмжилтийг сайжруулна. Энэ тухай олон илтгэгч цохон тэмдэглэж байсан, тухайлбал

бизнесийг илүү төгс харах тайлагналын үндэс нь өмнө судлагдаагүй зүйлийн хэмжүүр юм. Энэ шинэ үйл явц нь маш чанартай тоо, мэдээг бий болгодог. Мөн гадаад болон дотоодод шийдвэр гаргахад шаардлагатай мэдээ бийг болгодог. Компанийн нэгдмэл тайлагнал гэдэг бол дотоод гадаад тайлагналын уялдааг маш сайн бий болгодог хялбаршуулсан тайлагнал юм. Энэ тайлан нь зайлшгүй тайлагнах ёстой биш ч, дотоод шийдвэр гаргахад тодорхой хэмжүүр болох ба өөрөө биеэ даан хэрэгжүүлэх механизм болдог.

Нэгдмэл тайлагналын гадаад үр ашиг

Нэгдмэл тайлан нь байгууллагын үнэ цэнийн тухай мэдээллийг хялбаршуулсан тодруулгаар харуулдаг. Хэд хэдэн олон улсын хурлын үеэр мэргэжилтэн, судлаач нар нэгдмэл тайлагналын хэрэглээ тухайлбал хувьцаа эзэмшигчдийн шийдвэр, хуулийн зохицуулалт, хэмжилтийн үзүүлэлт, тайлагналын загвар, зохицуулагч нарын дүрэм журмын асуудлыг хэлэлцэж байна. Энэ тайлагнал бол маш олон сонирхогч бүлгүүдтэй харилцахад ашиглагддаг, жишээ нь одоогийн болон ирээдүйн ажилчид, түншүүд, захирлуудын зөвлөл, зохицуулагч байгууллагууд гэх мэт. Нэгэн менежментийн компанийн гүйцэтгэх захирал “...зах зээл нь нэгдмэл тайлагналын энэхүү мэдээллийг эрж хайж байна. Учир нь эдгээр мэдээлэл хөрөнгө оруулалтын боломжтой холбоотой учраас нийгэм, хүрээлэн буй орчин, засаглалын хүчин зүйлүүд нь улам бүр чухал юм”. Өөрөөр хэлбэл:

Нэгдүгээрт, байгууллагын үнэ цэнийг тайлагнана. Тухайн компани санхүү, үйлдвэрлэл, оюуны, хүний, нийгмийн харилцаа, байгалийн капиталуудын

өсөлт, бууралтаар үнэ цэнийг илэрхийлж тайлагнана.

Хоёрдугаарт, сонирхогч бүхий талуудад цогц мэдээллийг ижил цаг хугацаанд тайлагнана. Нэгдмэл тайлан нь сонирхогч талуудын мэдээллийн тэнцвэргүй байдлыг бууруулж, компанийн бизнес стратегийг сайн ойлгох, бизнес моделийг тогтвортой байлгах нь хөрөнгө оруулагч нарт итгэлийг бий болгодог. Хэдийгээр хөрөнгө оруулагч нар нь нэгдмэл тайлагналын суурь тоглогч мөн боловч бусад олон тооны сонирхлын бүлэг энэ тайлангаас мэдээлэл авч болно. Мөн бизнесийн талбарт тайлагналын өөрчлөлтийг авч ирдэг. Иймээс нэгдмэл тайлагналын урьдчилан тооцоогүй гадаад үр ашиг нь сонирхогч талуудын холбоог сайжруулдаг явдал юм.

Нэгдмэл тайланд шилжих шилжилтийн үед анхаарах асуудал

Нэгдмэл тайлагналыг сайжруулах болон бэлтгэх үйл явцыг эхлүүлэхийг 5 хэсэгт хувааж болох юм. Нэгдүгээрт, нэгдмэл ойлголтыг түгээн дэлгэрүүлэх хэрэгтэй; хоёрдугаарт, боломжит удирдамжийг ашиглах; гуравдугаарт, чанар сайтай мэдээ олж авах; дөрөвдүгээрт, хэрэглэгчдээ ойлгох; тавдугаарт, хариуцлагатай, найдвартай баталгаажуулалтыг бий болгох.

Нэгдмэл санаа бодлыг хөгжүүлэх

Нэгдмэл ойлголт нь бизнесийн үйл ажиллагаанд түлхэц үзүүлдэг. Нэгдмэл бодол санаа гэдэг бизнесийн үйл ажиллагааны болон нэгжүүдийн харилцааны хамаарлыг илэрхийлдэг. Хэлтэс нэгжүүдийн салангид байдлыг багасгаж бизнесийг цогцоор нь авч үздэг. Нэгдмэл бодол санаа нь дотоод маш олон үр ашигтай байдлыг бий болгодог. Тухайлбал бизнесийн модель дотор үнэ

цэнийн ойлголтыг авч үзэж нэгдмэл тайланг бэлтгэх, тайлагнах нь компаниудын төлөв байдал болон тайлагналыг сайжруулдаг. Олон янзын тайлангууд чухал биш харин хураангуй, товч тодорхой тайлангуудыг хэрэглэгч, сонирхогч талуудад хүргэдэг. Нэгдмэл ойлголт нь компанийн ирээдүйн үйл ажиллагаанд гүн тусгалаа олох учраас мэдээлэл нь хэлтсүүд, удирдлагын шийдвэр гаргалт болон гадаад тайлагналуудын хооронд чөлөөтэй урсдаг. Олон компаниуд нэгдмэл тайлан бэлтгэхэд бүх газар хэлтэс, харьяа нэгжүүдийн төлөөлөл орсон удирдах хороогоор удирдуулдаг.

Боломжит удирдамжуудын хэрэглээ, ашиглалт

Нэгдмэл тайлагналын цаашдын чиг нь компанийн тайлагналын ердийн хэрэглээ болох юм. Цогц тайлагналын стандартын хэрэглээ, үзэл баримтлал нь харьцуулах, харьцуулагдах, итгэлтэй харилцааг хөрөнгө оруулагч нарт харуулдаг. Эдгээр харьцуулагдахуйц, итгэл үнэмшилтэй байх зэргийг хялбар хэрэгжүүлж болно. Жишээ нь, Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмуудаар хийгдсэн үнэлгээ, тайлан, баталгаажуулалт зэрэг нь хоорондоо харьцуулагдах асуудлыг зохицуулсан байдаг. Нэгдмэл тайлан бол сайн дурын байдгаас харьцуулагдах боломж муу бөгөөд нэгтгэх боломжгүй юм. ОУНТЗ-өөс нэгдмэл тайлагналыг хэрэгжүүлэх зорилгод хүрэх хамгийн гол арга хэрэгсэл нь нэгдмэл тайлагналын үзэл баримтлал гэж үзэж байгаа. Түүнчлэн үзэл баримтлал нь нэгдмэл тайлагналыг түгээн дэлгэрүүлэх гол чиглүүлэгч нь юм. Нэгдмэл тайлагналын үзэл баримтлал нь мэдээллийг тайлагнах, хэмжих, шалгах нотлохыг зорьдог. Хуралд оролцсон илтгэгч болох нэгдмэл тайлан бэлтгэгчид,

үнэлгээчид, судлаачид үзэл баримтлалыг ашигласан гэдгээ дурьдаж байсан. Нэг судлаач хэлэхдээ нэгдмэл тайлагналын үзэл баримтлал их итгэл үнэмшилтэй байна, энэ бол нэгдмэл тайлагналын зорилгодоо хүрэх хамгийн сайн хэрэгсэл юм. Цаашдаа энэ тайланг нэвтрүүлэгч нар нь нэгдмэл тайлагналын үзэл баримтлалыг ерөнхий стандарт болгон хөгжүүлэх хэрэгтэй (ICGN-IIRC Conference, 2018).

Товч тодорхой мэдээ ашиглах

Нэгдмэл тайлан нь компанийн тайлагналд шинэ зүйл. Тиймээс нэгдмэл тайланд хамаарах мэдээллийн талаар нэгдсэн ойлголтонд хүрэх нь нэгдмэл тайлагналын үүсч хөгжсөн жилүүдэд тулгарсан бэрхшээлтэй асуудлын нэг юм. Хэрэгцээтэй товч, тодорхой мэдээлэл гэдэг бол дотоод, гадаадад тодорхой оносон шийдвэр гаргахад чухал юм. Нэгдмэл тайлагналд зориулж товч, тодорхой мэдээ цуглуулна гэдэг нь хэзээ ч төгсөшгүй цаг хугацаа шаардсан ажил байдаг. Олон эх сурвалжуудаас, тухайлбал, вэб сайт, интернэт, тайлан гэх мэтээс хэрхэн оновчтой мэдээллээ олж авах вэ гэдэг олон асуудал дагалдана. Нэгдмэл тайлагналын мэдээ нь түүхэн болон ирээдүйд чиглэсэн байдаг. Ирээдүйд чиглэсэн мэдээ гэдэг нь уламжлалт түүхэн мэдээнээс илүү цар хүрээг хамарсан мэдээ байдаг. Санхүүгийн бус мэдээ нь маш эмх замбараагүй, зохицуулалт, хэрэгжилт тааруу байдаг. Энэ мэдээ нь үнэн үү, эсвэл реклам сурталчилгаа юу, энэхүү мэдээллийг шийдвэр гаргахдаа хэрэглэх үү гэх мэт асуудал гарч ирдэг.

Хэрэглэгчдээ ойлгох

Нэгдмэл тайланг бэлтгэгч нь тухайн тайланг хэн хэрэглэх вэ гэдгээ сайн мэдсэн байх ёстой. ОУНТЗ-ийн

нэгдмэл тайлагналын үзэл баримтлал нь байгууллагын үнэ цэнийг хэрхэн бий болж буйг толилуулахыг зорьдог. Сонирхогч талууд гэдэгт хөрөнгө оруулагч, хэрэглэгч, бэлтгэн нийлүүлэгч, ажилчид, төрийн болон мэргэжлийн зохицуулагч байгууллагууд, газрын эзэд гэх мэт бүлгүүд байдаг. Нэгдмэл тайланг гаргаснаар гадаад өгөөж нь олон талын, тухайлбал, одоогийн болон ирээдүйн хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч, хэрэглэгчидтэй харилцах харилцааг бий болгодог. Хэрэглэгч, сонирхогч талуудын хүссэн мэдээ, мэдээлэл, саналыг хүлээн авснаар тайлангийн хамрах хүрээг тодорхойлох боломж бий болдог. Тэдгээр сонирхсон мэдээллийг тайлагнаснаар хэрэглэгчдийн сэтгэл ханамж, хэрэгцээг хангах, шийдвэр гаргах боломжийг олгодог. Санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг нэгтгэж үнэ цэнийг бүтээхэд идэвхитэй харилцаа хэрэгтэй. Тиймээс нэгдмэл тайлан нь хөрөнгө оруулагчдыг шийдвэрээ оновчтой гаргахад нь боломжийг олгодог.

Хариуцлагатай найдвартай баталгаажуулалтын асуудал

Нэгдмэл тайлан бол шинэ зүйл. Тиймээс баталгаажуулах асуудал дөнгөж яригдаж эхэлж байна. Сайн дурын баталгаажуулалт тул цаг хугацаа шаардана. Энэ тайлагналын баталгаажуулах систем нь тодорхой цаг хугацаа авах боловч үнэн зөв, итгэлтэй, найдвартай байдал чухал. Нэгдмэл тайлагналын баталгаажуулалттай холбоотой 2 асуудал байна.

Нэгдүгээрт, илтгэл мэдээллээс үзэхэд баталгаажуулалттай холбоотой мэдээллийн зөрүү их байна. Санхүүгийн тайлагналын баталгаажуулалтаас өөр маш олон баталгаажуулагчид оролцож болно. Учир нь санхүүгийн бус олон

мэдээлэл байдаг учир олон төрлийн баталгаажуулалт хэрэгтэй. Энэ бол өргөн хүрээний бөгөөд чухал асуудал. Олон төрлийн баталгаажуулалтын хүрээг гаргах шаардлагатай бөгөөд үүнд уламжлалт аудит, санхүүгийн компани, баталгаажуулалтын байгууллагууд, тусгай зөвлөхүүд, төрийн бус байгууллагууд, их дээд сургуулиуд, сонирхогч бүлгүүд байж болно. Нэгэн судлаач хэлэхдээ нэгдмэл тайлагналын баталгаажуулалт гэдэг нь сайн дурынх, өөр өөр хэрэгцээ, ач холбогдолтой байдгаас баталгаажуулалтын ажилд төлөх төлбөр, хөлс өөр өөр. Гэвч өргөн хүрээнд баталгаажуулалтыг хийж буй талууд нь компанийн хэрэгцээнд тохирсон үнийн сонголтыг хүлээн зөвшөөрдөг. Нэгдмэл тайланд зориулсан мэргэшсэн мэргэжилтэний боломж одоо л хөгжиж байна (ICGN-IIRC Conference, 2018).

Хоёрдугаарт, баталгаажуулалтын нэгдсэн зориулалт бүхий стандарт байхгүй. Хязгаарлагдмал болон шалтгаант баталгаажуулалт байдаг. Мөн хосолсон баталгаажуулалт байдаг. Шалтгаант баталгаажуулалт нь аудитын арга техникийг хэрэглэдэг. Хязгаарлагдмал баталгаажуулалт нь явцын түвшинд баталгаажуулалт хийдэг.

Нэгдмэл тайлагналын үйл явц

ОУТНЗ нь гаргасан үзэл баримтлалынхаа дагуу нэгдмэл тайлан гаргаж байгаа компаниудын мэдээ, мэдээлэл, тайлангаар мэдээллийн баазыг бүрдүүлж байна. Одоогоор 40 гаруй орны 100 гаруй салбар салбарын үйл ажиллагаа эрхэлдэг компаниудыг туршилтын программд хамруулсан. Мэдээллийн бааз нь анхлан нэгдмэл тайлангаа гаргаж буй компаниуд болон тайлангаа сайжруулахыг хүсэж буй компаниудад хөшүүрэг, дэмжлэг болж чадна.

Дүгнэлт

Дээрх олон улсын хурлууд, илтгэгч, зохицуулагчдын судалгаа, илтгэлүүд дээр ажиглалт хийж дүгнэхэд: Нэгдмэл тайлан нь компанийн үнэ цэнийг хэрхэн бий болгож буйг тайлагнаж байна. Үүнийг өнөөгийн бизнес загварчлал, тайлагналын гол өөрчлөлтүүд баталж байна. Үнэ цэнийг бий болгож буй санхүүгийн бус мэдээллийг хүлээн зөвшөөрч байгаа нь бодит зүйл юм. Нэгдмэл тайлан нь нэгдмэл санаа бодлыг илэрхийлэх хэрэгсэл нь болно. Нэгдмэл тайлан нь ирээдүйд албан ёсны тайлан байх чиглэл руу явна.

Манай улсын хувьд нэгдмэл тайлангийн асуудлыг дүгнэхэд дараах байдалтай байна. Үүнд:

1. Нэгдмэл тайлагналын тухай нэгдсэн ойлголтгүй байна. Өөрөөр хэлбэл нэгдмэл тайлагналын тухай ойлголт нийгэм, олон нийт, бодлого тодорхойлогч, хууль тогтоогч, хөрөнгө оруулагчид зэрэг хэрэглэгч бүх талуудын дунд маш муу байна.
2. Төрийн өмчит болон хувийн компаниуд өөр өөр цаг хугацаанд уялдаа муутай олон төрлийн тайлангууд гаргаж байна. Эдгээр нь ихэвчлэн санхүүгийн үзүүлэлт бүхий тайлангууд байна. Харин засаглал, нийгэм, хүрээлэн буй орчин, тогтвортой байдал зэрэг санхүүгийн бус мэдээлэл бага байна. Гэвч олон нийтийн зүгээс компаниудыг үнэ цэнээ ил тод, нээлттэй, хариуцлагатай тайлагнах, нийгэм болон хүрээлэн буй орчинд ээлтэй бизнес явуулахыг хүсэж байна.
3. Байгууллагын үнэ цэнийг тодорхойлогч, бүрдүүлэгч санхүүгийн, үйлдвэрлэлийн, оюуны, хүний, нийгмийн харилцааны болон байгалийн капиталуудыг бүрэн тайлагнахгүй байна. Манай

ихэнх бизнесийн байгууллага ашигт суурилсан бизнес загварчлалтай байна. Өөрөөр хэлбэл сүүлийн үеийн инноваци болох үнэ цэнэд суурилсан бизнес загварчлал дутмаг байна.

4. Бүртгэл, хэмжилт, тайлагналын эрх зүйн орчин төгс бүрдээгүй, төрийн болон мэргэжлийн зохицуулагч байгууллагуудын үүрэг оролцоо дутмаг байна.

Иймд “Нэгдмэл тайлагналын үндэсний

хөтөлбөр”-ийг баталж, хэрэгжүүлэх саналыг дэвшүүлж байна. Энэ хүрээнд нэгдмэл тайлагналыг судлах, таниулах, хөрөнгө оруулагчид, нээлттэй компаниуд болон бүхий л хэрэглэгчдийг хамарсан суурь судалгаа хийх, хэрэгжүүлэх үе шатыг тодорхойлох, эрх зүйн орчныг бүрдүүлэх, төрийн болон мэргэжлийн зохицуулагчдыг бий болгох, туршилтын компаниудыг хамруулах зэрэг олон үе шаттай ажлуудыг авч үзэх боломж бүрдэнэ.

Хавсралт 1. Нийтлэг бэлтгэдэг тайлангууд

Үзүүлэлт	Жилийн тайлан	Нэгдмэл тайлан	Нийгмийн хариуцлагын тайлан	Хүлэмжийн хийн ялгарлын тайлан
Зорилго	Үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн дэлгэрэнгүй гүйцэтгэлийг харуулна.	Байгууллагын засаглал, стратеги, гүйцэтгэл, хэтийн төлөв гадаад орчны хүрээнд; богино, дунд, урт хугацаанд үнэ цэнийг бий болгож байгааг харуулна.	Байгууллагын эдийн засаг, хүрээлэн буй орчин, нийгмийн нөлөөллийг харуулна.	Хүлэмжийн хийн ялгарлын түвшин, түүний нөлөөллийн ойлголтыг харуулна.
Хэрэглэгч	Одоогийн болон ирээдүйн хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид	Хөрөнгө оруулагч, санхүүжүүлэгч, зохицуулагч байгууллага болон бүх талын сонирхогчид	Ажилчид, хувьцаа эзэмшигчид, зохицуулагч байгууллага, орон нутгийн холбоод	Засгийн газар
Агуулга	- Санхүүгийн тайлангийн шинжилгээ, удирдлагын хэлэлцүүлэг - Аудиторын тайлан	- Түүх, гадаад орчин - Засаглал - Бодлого стратеги - Бизнес загвар - Эрсдэл, боломж - Нөөцийн хуваарилалт - Гүйцэтгэл - Хэтийн төлөв	- Стратеги, анализ - Түүх - Тайлангийн параметр - Удирдлагын хандлага - Гүйцэтгэлийн үзүүлэлт	Хүлэмжийн хийн хэмжээ
Тайлангийн үзэл баримтлал	- Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт - Нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим	- Нэгдмэл тайлагналын үзэл баримтлал	- Глобал тайлагналын санаачлагын стандартууд - НҮБ-ын Даян дээрхийн гэрээ	- Хүрээлэн буй орчныг хамгаалах агентлаг

Хавсралт 2. Нийтлэг бэлтгэдэг тайлангууд

Үзүүлэлт	Тогтвортой байдлын тайлан	Засаглалын тайлан	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тайлан
Зорилго	Тогтвортой хөгжлийг дэмжих, тайлагнах	Сайн засаглалыг бий болгох	Уул уурхайн ил тод, хариуцлагатай байдал, тайлагналыг бий болгох
Хэрэглэгч	Одоогийн болон ирээдүйн хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид, төрийн болон мэргэжлийн зохицуулагч байгууллагууд	Хөрөнгө оруулагч, санхүүжүүлэгч, зохицуулагч байгууллага болон бүх талын сонирхогчид	Ард түмэн, олон нийт, ажилчид, зохицуулагч байгууллага, орон нутгийн холбоод
Агуулга	<ul style="list-style-type: none"> - Эдийн засгийн үзүүлэлт - Нийгмийн харилцаа - Хүрээлэн буй орчин, экологи - Засаглал 	<ul style="list-style-type: none"> - Хувьцаа эзэмшигчид - Төлөөлөн удирдах зөвлөл, хороодын үйл ажиллагаа - Гүйцэтгэх удирдлага - ХЭ, ТУЗ-ийн хурлууд, ил тод тайлагнал 	<ul style="list-style-type: none"> - Уул уурхайн нөөц ашиглалт - Нөөц ашигласны төлбөр, хураамж - Улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар - Нөхөн сэргээлт - Нийгмийн хариуцлага, дэмжлэг, тусламж
Тайлангийн үзэл баримтлал	- Глобал тайлагналын санаачлага- GRI 201-419	- Компанийн засаглалын кодекс	<ul style="list-style-type: none"> - НҮБ-ын конвенци - НҮБ-ын Санаачилга 2008 - ОУИТБС-ын стандарт 2016
Зохицуулалт	Албан болон Сайн дурын	Албан болон Сайн дурын	Албан ёсны

Ашигласан материал

1. Ernst & Young (2013). EY's Excellence in Integrated Reporting
2. IIRC (2013). The International Integrated Reporting Framework
3. IIRC (2014). Realizing the Benefits: The Impact of Integrated Reporting
4. IIRC (2015). Integrated Reporting
5. KPMG (2013). Integrated Reporting in Practice: The South Africa Story
6. www.capa.com.my/19th-capa-conference-a-success
7. www.icgn.org
8. www.icgn.org/events/icgn-iirc-tokyo-conference-2018
9. www.integratedreporting.org
10. www.wcoa2014rome.com